

Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг
сонгон шалгаруулах урилга

Огноо: 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

Сонгон шалгаруулалтын нэр: “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудалд байр талбай түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулах тухай” 51 дүгээр тогтоолыг үндэслэн “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудалд нийт 1,586.03 м.кв байр талбайг үйлчилгээний зориулалтаар түрээслэх түрээслэгчдийг сонгох сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

Шалгаруулалтад оролцогч иргэн, хуулийн этгээд нь 2023 оны 01 дүгээр сарын 05–ны өдрийн 10.00 цагаас өмнө “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын 4 давхарт 403 тоотод материалаа битүүмжлэн материалын жагсаалтын /дугтуйны гадна талд бичсэн/ хамт ирүүлсэн байна.

1. Түрээслүүлэх байр талбайн танилцуулга

№	Түрээслүүлэх талбайн нэршил, чиглэл	Талбайн хэмжээ	Байршил, тайлбар
“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын 2 давхарт			
1	Түрээслүүлэх талбай	56.03 м.кв	Нисэх буудлын 2 давхарт Нэг цэгийн үйлчилгээний хажууд нотариатын зориулалтаар /хэсэгчилэн түрээсэлж болно/
“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын дээврийн давхарт тоног төхөөрөж байршуулах			
2	Түрээслүүлэх талбай	30 м.кв	Нисэх буудлын дээврийн /хэсэгчлэн түрээсэлж болно /
“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын 2 давхарт			
3	Түрээслүүлэх талбай	1500 м.кв	Нисэх буудлын 2 давхарт албан тасалгааны зориулалтаар /хэсэгчлэн түрээсэлж болно/

2. Сонгон шалгаруулалтын ерөнхий мэдээлэл

Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа	2023 оны 01 дүгээр сарын 05-ны 10.00 цагаас өмнө
Материал хүлээн авах хаяг	УБ хот, Хан-Уул дүүрэг, 21-р хороо, “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал, 4 давхар 403 тоот
Материал нээх хугацаа, хаяг байршил	“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал, 2 давхар, Онцгой байдлын хурлын танхим 2023 оны 01 дүгээр сарын 05-ны 11.00 цагт нээнэ.
Нэг сард 1 м ² талбай түрээслэх үнийн доод хэмжээ /НӨАТ ороогүй /	Эд хөрөнгө түрээслүүлэх 1м.кв талбайн түрээсийн жишиг доод үнэ үйл ажиллагааны чиглэлээс хамааран дараах нөхцөлтэй байна. Үүнд: 1. Төрийн үйлчилгээний албан тасалгааны зориулалтаар- 15.000₮ 2. Худалдаа үйлчилгээ - м.кв 30.000₮ 3. Банк санхүүгийн үйлчилгээ – м.кв 50.000₮ 4. Ачаа тээврийн үйлчилгээ – м.кв 20.000₮ 5. Тоног төхөөрөмж байрлуулах /1ш/ – 50.000₮ 6. АТМ, Кофены машин, массажны сандал байрлуулах /1ш/ – м.кв 150,000₮ 7. Бусад- 60.000₮
Оролцогчдын бүрдүүлж ирүүлэх материал	<u>Хуулийн этгээдийн хувьд</u> <ul style="list-style-type: none">• Улсын бүртгэлийн гэрчилгээ /e-mongolia цахим хуудаснаас авах/• Үйл ажиллагааны танилцуулга, ажлын туршлагын талаарх сүүлийн 3 жилийн мэдээлэл, гэрээний хуулбар;• Аудитлагдсан санхүүгийн тайлан; /сүүлийн 2 жил /• Татварын тодорхойлолт; /e-mongolia цахим хуудаснаас авах/

	<ul style="list-style-type: none"> • Шүүхийн тодорхойлолт; /e-mongolia цахим хуудаснаас авах/ • Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт/e-mongolia цахим хуудаснаас авах/ • Ажиллах хүчний мэдээлэл, мэргэжлийн диплом, үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар; • Нэг сарын 1 м² талбайг түрээслэх үнийнсанал <u>/НӨАТ-гүй үнэ/</u> <u>Иргэний хувьд</u> • Иргэний үнэмлэх /e-mongolia цахим хуудаснаас авах/ • Харилцагч банкны тодорхойлолт /зээл/ сүүлийн 1 жилийн дансны хуулга • Оршин суугаа газрын тодорхойлолт; /e-mongolia цахим хуудаснаас авах/ • Ажиллах хүчний мэдээлэл, мэргэжлийн диплом, үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар; • Нэг сарын 1 м² талбайг түрээслэх үнийнсанал <u>/НӨАТ-гүй үнэ/</u> Жич: Сонгон шалгаруулалтад оролцох этгээд нь сонирхсон байр талбайг түрээслэх чиглэлийг тодорхойлж, өөрийн саналыг ирүүлнэ.
--	--

3. Түрээслэгчийг сонгон шалгаруулах зааврын талаарх товч мэдээлэл

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 49 дүгээр тогтоолын дагуу Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай тогтоол.
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 50 дугаар тогтоолын хавсралтын дагуу “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар”.
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 51 дүгээр тогтоолын дагуу Төрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

4. Түрээслүүлэх хөрөнгийн талаар мэдээлэл авах

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудалд байрлалтай түрээслүүлэх байр талбайтай танилцах болон сонгон шалгаруулалтын заавар, бүртгэх хугацаа, хөрөнгийн талаарх мэдээллийг 71-283253 болон Buyant-Ukhaa@airport.gov.mn цахим хуудаснаас авна уу.

ХАЯГ: “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал.

Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа, Улаанбаатар хот 17120